

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТӨСВИЙН НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сэмжаан Батцэцэг¹, Очир Ирвэс², Төмөр Гансүх^{2,3}

¹ Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Судалгаа арга зүйн тэнхим,

² Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны сектор,

³ Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик, байгалийн ухааны сургууль, Математикийн тэнхим

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2023.02.19

Засаж сайжруулсан: 2023.06.19

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2023.08.28

Түлхүүр үг:

боловсролын санхүүжилт,
ерөнхий боловсролын төсөв,
санхүүжилт, төсвийн нийгэм,
эдийн засгийн үр нөлөө, үр ашиг

Холбоо барих зохиогч:

Очир Ирвэс

Боловсролын судалгааны үндэсний
хүрээлэн, Боловсролын эдийн
засаг, менежментийн судалгааны
сектор

Email: irves@mnier.mn

Хураангуй

Монгол улс сүүлийн жилүүдэд шинэ мэдлэгт суурилсан салбаруудыг хөгжүүлэх, нийгэм, эдийн засаг, боловсролын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого боловсруулахад ихээхэн анхаарч байна. Монгол иргэнийг бэлтгэхийн тулд чанарын олон шинэчлэлүүдийг боловсролын зорилтыг хангах санхүүжилтийн механизмтай нь уялдуулан боловсруулж, хэрэгжүүлж ирсэн байна.

Манай улсад газар зүйн онцлог, хүн ам зүйн бүтэц, боловсролын тогтолцооны өмнө тулгамдаж буй асуудал, цаашдын хэрэгцээ шаардлага зэрэг дотоод, гадаад олон хүчин зүйлийг харгалзан үзэж боловсролын салбарын төсвийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах зэрэг төсвийн процессыг иж бүрнээр нь, үр дүнтэй хэрэгжүүлэх урт хугацааны, тогтвортой бодлого, санхүүгийн удирдлага чухал байна.

Үүний зэрэгцээ тогтвортой, урт хугацааны санхүүгийн бодлогыг улс болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхүйц боловсролын салбарт мэргэшсэн санхүүгийн удирдлага, хүний нөөц (төрийн санхүүч, эдийн засагч, судлаач)–ийг бэлтгэх, орон нутгийн боловсролын байгууллагуудыг мэргэшсэн хүний нөөцөөр хангах асуудлыг төр бодлогоор дэмжих хэрэгцээ, шаардлага байна.

Ерөнхий боловсрол нь улсын төсвөөс санхүүждэг ба норматив зардлын жишиг тогтоох үзүүлэлтүүд нь хэд хэдэн удаа шинэчлэгдэж мэдээллийн олдоц хязгаарлагдмал байна. Бид ҮСХ, 1212.mn болон БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэсэн болно. Энд боловсролын салбар, тэр дундаа ерөнхий боловсролын төсвийн зардал, санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвийн урсгал зардлын үзүүлэлтээр, нийгмийн үр нөлөөг макро эдийн засгийн зарим үзүүлэлтээр хэмжээсжүүлж тэдгээрийн харилцан хамаарлыг судалж, дүгнэхдээ сүүлийн 11 жилийн өгөгдөл, мэдээлэлд үндэслэн боловсруулалт хийсэн болно.

Энэхүү өгүүлэлд ерөнхий боловсролын төсөв болон нийгэм, эдийн засгийн зарим макро үзүүлэлтийн харилцан

**A study results of investing
social impacts on budgeting
at secondary education level
in Mongolia**

Abstract

Authors

Battsetseg, S¹., Irves, O².,
Gansukh, T^{2,3}

¹School of Educational
Studies, Mongolian National
University of Educational,

²Education Economics and
Management Research Sector,
Mongolian National Institute
for Educational Research,

³School of Mathematics and
Natural Sciences, Mongolian
National University of
Educational

Keywords:

funding for education, general
education budget, funding
social and economic effects
and efficiency of the budget

Nowadays, Mongolia has been considering to the improvement of new knowledge-based industries, contributing to development of the social, economic, and educational sectors, and developing government policies on education. In order to prepare Mongolian citizens, many quality reforms have been developed and implemented in coordination with the financing mechanism to meet the educational goals. In our country, it needs the long-term and sustainable policies and financial management are important for the comprehensive and effective implementation of the budget process, such as development, planning, operation and control of the budget for the education sector, to allow for many internal and external factors for instance, geographical features, demographic structure, problems facing the education system. Therefore, there is a need and requirement to support the provision of qualified human resources to local educational institutions by training specialized financial management and human resources (public financiers, economists, researchers) in the field of education to implement sustainable and long-term financial policies at the national and local levels. General education has financed from the state budget, and the normative cost benchmarking indicators are updated several times, so the availability of information is limited. We are based on detailed information from the National statistical commission, 1212.mn and the Ministry of Finance and Investment Department.

At this point, the education sector is including general education budget expenses and fundings which are measured by current state and local budget expenditure indicators, social effects are measured by some macroeconomic indicators, and their interrelationships are studied and evaluated based on the data and information of the last 11 years.

This article presents the results of a study that describes the relationship between the general education budget and some macro indicators of society and economy.

УДИРТГАЛ

Өнөө үед ямар ч төр, засгийн өмнө нийгмийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийг урагшлуулах зорилго тулгардаг бөгөөд үүнийг боловсролын сайн засаглал, бодлого, тогтолцоогүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм. Нийгэм гэдэг нь хүн, эдийн засаг гэдэг нь нийгмийн гишүүдийн материаллаг хэрэгцээг хангах нөөц баялаг бүтээх асуудал юм. Тодруулбал, аливаа нийгмийг хөгжүүлэх гэдэг нь хүнийг хөгжүүлэх бөгөөд энэ нь оюуны болон материаллаг байдлыг хамтад нь дээшлүүлэх асуудал гэж ойлгож байна.

Төрийн бодлого шийдвэр түүний дотроос төсөв санхүүгийн бодлого чиглэл нь хүмүүсийн өдөр тутмын амьдрал болон үйл ажиллагаанд шууд нөлөөлж байдаг бөгөөд эцэст нь улс орны хөгжил дэвшлийн үндсэн асуудал болж байдаг. Манай улсын хувьд хэдийгээр нэг хүүхдийг сургахад харьцангуй бага мөнгө төрөөс ч, эцэг эхээс ч зарцуулж байгаа мэт харагдах боловч ДНБ-ээс зарцуулж буй хувиараа бусад улстай харьцуулахад дэлхийн дунджийн түвшинд байна (ҮСХ, 2022). Иймээс боловсролын салбарын үр дүнг түүнд зарцуулсан санхүүжилт, төсвийн хэмжээнээс хамааруулан тооцож, уялдаа холбоог тодорхойлох нь цаашид юу хийх, төлөвлөх ажлын үндэс суурь болох юм.

Боловсрол, сургалтад оруулах хөрөнгө оруулалт, түүний үр өгөөжийг судлах нь хүмүүн капиталын онолын судалгааны гол хэсэг юм (Jacob Mincer, 1957). Хүн сургуульд суралцахдаа ирээдүйд сайн сайхан ажил хийж, сайхан амьдарна гэж итгэдэг. Хувь хүний хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоходоо боловсролд зарцуулсан нийт хөрөнгө оруулалтыг тухайн хүний боловсрол эзэмшсэнээрээ олох нэмэлт орлоготой, харин нийгмийн өгөөжийг тооцоходоо тухайн нийгмийн боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалтыг түүнээс хүртэж болох эдийн засгийн үр ашигтай харьцуулдаг. Түүнчлэн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх боловсролын нөлөөлөл дээр нийгмийн өгөөжийг мөнгөөр хэмжээсжүүлж оруулахыг хичээдэг (Gary Becker, 1964).

Үүнтэй уялдан төр, засгаас боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалт, татвар, зээл, эдийн засгийн хэмнэлт, түүний урамшуулал, хариуцлагын ямар санхүүжилтын бодлого, стратеги, хууль эрх зүйн зохицуулалт хийх чиглэлээр боловсролын эдийн засгийн гүнзгийрүүлсэн бие даасан судалгаа, шинжилгээний ажил хийх хэрэгцээ, шаардлага улам бүр өсч байна. Өөрөөр хэлбэл, боловсролын төсөв, санхүүжилт, түүний ашиглалтын өгөөж, үр ашгийг тооцоолж, үнэлж, дүгнэдэг уламжлалт арга, хэлбэрийг өөрчилж, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болсон.

Боловсролын салбарын жилийн улсын төсвийн орлого, зарлагын хэмжээ жил бүр өсч 1 их наяд гаруй төгрөг буюу улсын төсвийн орлогын 20-иос доошгүй хувийг эзэлдэг болсон. Өөрөөр хэлбэл, манай орны хамгийн их төсөв зарцуулдаг нийгмийн дэд салбар болоод байна. Гэвч ерөнхий боловсролын түвшинд энэхүү томоохон санхүүжилт, төсөв, хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн өгөөж, үр ашиг, үр нөлөөг байнга тооцоолж, үр дүнг төсөв, санхүүжилтийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлтөд цаг тухайд нь тусгаж чадахгүй байна.

Мөн ерөнхий боловсролын санхүүжилтийн эдийн засгийн үр ашгийг тооцоолох онол арга зүй, аргачлал, нэр томъёоны асуудал нэг мөр болоогүй, боловсролын эдийн засгийн зохих түвшний сургалт, бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт цогц байдлаар тодорхой тусгаагүй, түүнчлэн мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоо орчин, сурах бичиг, арга зүй, багш, судлаачийн нөөц боломж хараахан бүрдээгүй байна.

Иймээс бид ерөнхий боловсролын төсөв ба нийгмийн үр нөлөөг тооцох үзүүлэлүүдийн хамаарал, хугацааны хоцрогдол зэргийг хэрхэн хэмжээсжүүлж, тооцох талаар гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнгээс тоймлон, улмаар өөрийн судалгааны үр дүнгээ танилцуулах, түгээн дэлгэрүүлэх болно. Энэхүү судалгааны хүрээнд манай орны ерөнхий боловсролыг XXI зууны шинэ тутам хурдацтай бий болж байгаа эрэлт хэрэгцээ шаардлага, улсын, хувийн, гадаадын болон хамтарсан сургууль, насан туршийн боловсрол-цахим сургалтын санхүүжилтийн олон янзын эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлж, түүнийг үр ашиг, үр нөлөөг үндэсний болон байгууллагын түвшинд хэрхэн тооцоолох, ач холбогдол, үнэ цэнийг ойлгох, түүнчлэн цаашид санхүүжилт, төсвийн үр ашгийг дээшлүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ хэмээн үзэж байна.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Боловсрол, түүний дотор ерөнхий боловсролын дэд салбарт улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламжийн багагүй санхүүжилт хийгдэж байгаа боловч орчин үеийн шинэ эрэлт хэрэгцээ шаардлагатай уялдсан санхүү, хөрөнгийн дутагдал байсаар байна.

Ерөнхий боловсролын санхүүжилт нь 30 гаруй жилийн өмнө зөвхөн улс, орон нутгийн төсвийн орлого, дотоодын хөрөнгө оруулалтаас түлхүүтэй бүрддэг байсан бол эдүгээ тэдгээрээс гадна гадаад улс орнууд, олон улсын санхүүгийн донор байгууллагуудын техникийн тусалцаа, буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлийн төсөл, хөтөлбөрүүд, төрийн бус олон нийтийн байгууллагын болон уул уурхай, бизнесийн түншүүдийн хандив, дэмжлэгийн шинэ эх үүсвэрүүд бий болж байна.

Эндээс харахаар ерөнхий боловсролын салбарын шинэчлэл, хөгжилд нэг талдаа санхүү, хөрөнгө ихээхэн дутагдаж байгаа боловч нөгөө талдаа олон ашиглагдаагүй нөөц боломж, хэмнэлтийн бодлогогүй үрэлгэн зардлууд багагүй байгааг зарим судалгаа, шинжилгээний үр дүнгээс харж болдог.

Боловсролын эдийн засаг, санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоо, түүний хөгжлийн бодлого, стратеги, менежмент, тэдгээрийн хэрэгжилт, эдийн засгийн үр ашиг, нийгмийн үр нөлөө, цаашдын чиг хандлагын талаар бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаач, эдийн засагч нар судалгаа, шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал, гадаадын эрдэмтэн судлаачид, Hanushek /1986, 2003/, Rivkin, Taylor, Doltan /2004/, Levacic.R, Vignoles.A, Rob Greenwald /1996, 2004/, Larry Hedges, Richard Laine/2011/ санхүүгийн нөөцүүд нь сурлагын амжилтад нөлөөлөх талаар, Coleman.S /2013/ зарцуулсан мөнгө боловсролын чанарт нөлөөлөх талаар, Leigh, Rayn /2015/ боловсролын бүтээмжид нөлөөлөх талаар судалж байжээ. Харин манай орны эрдэмтэн судлаач, эдийн засагчид боловсролын эдийн засаг, санхүүжилтийн асуудлаар судалгаа шинжилгээний ажлыг хийж, гадаад, дотоодод эрдмийн зэрэг хамгаалсан байна. Ялангуяа, АХБ-ны дэмжлэгтэйгээр 1995 онд олон улсын зөвлөх доктор И.Мемнаф, дотоодын зөвлөх Ж.Сүхбаатар, А.Батжаргал, Р.Бандий зэрэг үндэсний эрдэмтэн судлаачдыг баг хамтран Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын байршил, бүтэц, хэв шинж, багш, багш бус ажилтны орон тоо, тэдний тооны харьцаа, бүрэлдэхүүн, чанар, эдийн засгийн үр ашгийн талаар цогц судалгаа шинжилгээний ажил хийж, үнэлж, дүгнэлт гаргаж байжээ.

Боловсролын санхүүжилт, төсвийн тулгамдсан асуудал, сэдвээр судалсан бүтээл, судлаачид харьцангуй цөөн байгааг дараах эх сурвалжуудаас харж болохоор байна. Тухайлбал,

- Академич Н.Бэгзийн *1958-2021 онд боловсролын чиглэлээр дэд эрдэмтэн, дэд доктор, докторын зэрэг хамгаалсан ажлуудын судалгааны жагсаалтад нийтдээ 610 эрдэмтний нэр судалгааны сэдэв, хамгаалсан он дурьдагдсны дотор Монгол Улсын ерөнхий боловсролын санхүүжилт, төсвийн чиглэлээр бие даан гүнзгийрүүлэн төрөлжүүлэн эрдмийн зэрэг хамгаалсан судлаач байхгүй байна* (“Монголын боловсрол” нэвтэрхий толь. Боть I. НЭПКО 2021. Хууд 381-402).
- Доктор Г.Өлзийсайханы *1987-2017 онд хамаарах 59 боловсролын удирдлагын докторын бүтээл, (Шинжлэх ухаан, технологийн сангийн цахим хуудас, МУБИС-ийн төгсөгчдийн бүртгэлийг ашигласан), 2002-2017 оны хооронд эрдэм шинжилгээний сэтгүүлд боловсролын удирдлагын чиглэлээр хэвлэгдсэн 148 өгүүлэлд дүн шинжилгээ хийж боловсролын эдийн засаг, төсөв санхүү, түүх, хууль эрх зүйн чиглэлийн судалгаануудыг харьцангуй цөөн хийгдсэн байна* (Өлзийсайхан Г, 2018).

Иймд боловсролын хөгжлийн болон санхүүжилтийн бодлого, стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, мониторинг хийж, үнэлж дүгнэх төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, судалгаа шинжилгээ, хяналт, үнэлгээ, цахим мэдээллийн төрөлжсөн байгуулгыг бий болгож тогтвортой

ажиллуулах хэрэгцээ шаардлага байсаар байна. Үүнтэй уялдан 2021 оноос Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны сектор тусдаа байгуулагдсан нь сайн эхлэл юм.

Сүүлийн 30 гаруй жилд ерөнхий боловсролын салбарт бодлогын, удирдлага, зохион байгуулалт, бүтэц, байршлын, сургалтын агуулга, арга технологи, хүний нөөц, дэд бүтцийн хөгжилд маш олон шинэлэг өөрчлөлтүүд бий болж байгаатай уялдаж түүний санхүүжилтийн тоо хэмжээ, арга хэлбэрт багагүй өөрчлөлтүүд бас бий болсон. Цаашид ч XXI зууны дэлхий дахины болоод монгол орны хөгжлийн хандлага, тогтвортой хөгжил, үйлдвэржилтийн 4 дүгээр хувьсгал, ногоон, дижитал ухаалаг технологи, дэлхийн иргэнийг бэлтгэх, насан туршийн боловсрол, цахим нээлттэй боловсрол олгохтой уялдаж ерөнхий боловсролын санхүүжилтийг нэмэгдүүлэх үү, эсвэл үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах уу зэрэг асуудлууд шийдлээ хүлээсээр байгаа юм.

АРГА ЗҮЙ

Боловсролыг төрөөс санхүүжүүлэхийн тулд татвар төлөгчдөөс хөрөнгө татан төвлөрүүлж, сургалтын байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хуваарилдаг. Төр татвар төлөгчийн өмнө төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийн талаар хариуцлага хүлээж, сургуулиуд төрийн өмнө хариуцлага хүлээдэг. Татвар төлөгчид төрөөс мөнгийг хамгийн их үр ашигтай, үр дүнтэй зүйлд зарцуулж, нийгмийн сайн сайхан байдлыг бий болгохыг шаарддаг. Харин төр сургалтын байгууллагаас хуваарилсан мөнгийг үр ашигтай, үр дүнтэй (цаашид нийгмийн үр нөлөө гээ) зарцуулах буюу боловсролын үйлдвэрлэлийн гарцыг хамгийн их байлгахыг шаарддаг.

Иймээс нийгмийн үр нөлөөг тооцох шинжилгээ нь зарцуулж буй хөрөнгөөр хүрэхээр тавьсан зорилтоо биелүүлсэн эсэх, хийхээр төлөвлөгдсөн зүйлээ хийсэн эсэх, хийхээр төлөвлөсөн зорилтыг биелүүлэхэд юу хэрхэн нөлөөлж байгааг тооцоход хэрэглэгддэг байна.

Үүний тулд орцын үзүүлэлтээр ерөнхий боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зардлын хэмжээг авна. Харин оюуны үйлдвэрлэлийн гарцын буюу нийгмийн үр нөлөөг тооцох үзүүлэлтийг а) ажилгүйдлийн түвшин, б) ядуурлын түвшин /ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь/, в) татварын орлого /орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамж/ гэсэн үзүүлэлтээр тус тус сонгон судлах болно. Өөрөөр хэлбэл, боловсролын нийгмийн үр нөлөөг тооцоходоо мөнгөөр хэмжиж тооцоход бэрхшээлтэй хэдий тусгах боломжтой үзүүлэлтүүдийг сонгов. Харин эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтээр дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ сонгосон болно.

Боловсролд зарцуулсан зардал үр ашигтай байсан эсэхэд шинжилгээ хийхдээ:

- Хамаарал байгаа эсэхийг корреляцийн шинжилгээгээр
- Хэрэв хамааралтай бол зүй тогтлыг регрессийн шинжилгээгээр тус тус тодруулж, дүгнэлт гаргах болно.

Өгөгдөл мэдээллийн тохирц, найдвартай байдал: Боловсролын салбарын мэдээллийн системийг Ерөнхий боловсролын салбарт 2013 оноос, сургуулийн өмнөх боловсролын салбарт 2018 оноос нэвтрүүлж регистрт суурилсан онлайн мэдээллийн сан бүрдүүлснээр

мэдээллийн найдвартай, үнэн зөв байдлыг хангах болсон байна. Нийгмийн статистик үзүүлэлтийг ҮСХ, 1212.mn –ээс авсан болно. Иймээс ”Боловсролын секторын дүн шинжилгээ хийх арга зүй”-д шалгуур үзүүлэлтийг баримталж, хэмжээсжүүлж болохуйц байдал, хугацааны цувааны бүрдүүлэлт зэргээс хамааруулан хийсэн болно.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол улсын ерөнхий боловсролын төсөв болон нийгмийн үр нөлөөг тооцох зарим үзүүлэлтийн хамаарлыг тооцох, хугацааны хоцрогдол тооцох, улмаар өнөөгийн хүрсэн ололт, амжилт болон цаашид анхаарах асуудал, шийдлийг танилцуулах, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Судалгааны зорилтууд:

1. Олон улсын болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын боловсролын гадаад, дотоод эдийн засгийн үр ашгийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт, арга зүйг судлах, үр дүнг өөрийн судалгааг хийх онол-арга зүйн үндэс болгох,
2. Ерөнхий боловсролын төсвийн зардал болон нийгмийн үр нөлөөг тооцох зарим макро үзүүлэлтийн хамаарлыг тооцох, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах,

ҮР ДҮН

Энд Монгол Улсын хэмжээнд тооцогдсон макро үзүүлэлтүүдийг ашиглан ерөнхий боловсролын төсвийн зардал урт хугацаанд үр ашигтай гэсэн тооцооллыг 10 жилийн хоцрогдолтой байхаар тооцож үр дүнг нэгтгэв. (Энд эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх боловсролын нөлөөлөл дээр нийгмийн үр нөлөөг мөнгөөр хэмжээсжүүлж тооцох тул зөвхөн ДНБ-г сонгосон болно)

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтээр хамаарлын хүчийг тодорхойлсон үр дүн, ач холбогдлын түвшин

Correlations			
		Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан зардал, сая төг	ДНБ, оны үнээр
Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан зардал, сая төг	Pearson Correlation	1	.953**
	Sig. (2-tailed)		.000
	N	21	11
ДНБ, оны үнээр	Pearson Correlation		1
	N		11
**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).			

Ерөнхий боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт 10 жилийн дараах эдийн засгийн өсөлтийг хангаж (шууд, хүчтэй хамааралтай) чадаж байна. Өөрөөр хэлбэл, 10 жилийн өмнөх ерөнхий боловсролын салбарт зарцуулсан төсвийн хөрөнгө нь өнөөгийн ДНБ-ний хэмжээний өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна. ДНБ-ий өсөлтийн 89.7 хувийг ерөнхий боловсролын төсвийн зардал дангаараа тайлбарлаж чадах бөгөөд дүгнэлт статистикийн ач холбогдолтой байна. Иймд хэмжих нэгжээрээ хэрхэн нөлөө үзүүлэхийг тус бүрд нь авч үзье.

Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтээр хамаарлын хэлбэрийг тодорхойлсон үр дүн, ач холбогдолын түвшин

Model Summary									
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Change Statistics				
					R Square Change	F Change	df1	df2	Sig. F Change
1	.953 ^a	.907	.897	2924165.6	.907	88.139	1	9	.000
a. Predictors: (Constant), Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан зардал, сая төг									
ANOVA ^a									
Model	Sum of Squares		df	Mean Square		F	Sig.		
1	Regression	753652108735414.4	1	753652108735414.4		88.139	.000 ^b		
	Residual	76956703961283.9	9	8550744884587.1					
	Total	830608812696698.2	10						
a. Dependent Variable: ДНБ, оны үнээр									
b. Predictors: (Constant), Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан зардал, сая төг									
Coefficients ^a									
Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients		t	Sig.		
		B	Std. Error	Beta					
1	(Constant)	9431861.681	1773292.123			5.319	.000		
	Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан зардал, сая төг	.132	.014	.953		9.388	.000		
a. Dependent Variable: ДНБ, оны үнээр, сая төг									

Ерөнхий боловсролын салбарт зарцуулсан санхүүжилт, төсвийн хэмжээг 1 сая төгрөгөөр нэмэгдүүлэхэд ДНБ-ний хэмжээ 0.132 сая төгрөгөөр өснө. Статистикийн ач холбогдолтой байна.

Нийгмийн үр нөлөөг ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин, татварын орлого гэсэн үзүүлэлтүүдээр тооцсон үр дүн:

Хүснэгт 3. Нийгмийн үр нөлөөг тооцох үзүүлэлтээр хамаарлыг тодорхойлсон үр дүн, ач холбогдлын түвшин

Хамаарал байгаа эсэхийг тодорхойлох үзүүлэлт	Ядуурал	Ажилгүйдэл	Татварын орлого
Корреляцийн коэффициент	-0.346	-.944**	.910**
Sig. (2-tailed)	0.052≥0.05	0.000≤0.05	0.000≤0.05
N	11	11	11
Ерөнхий боловсролын салбарын төсвийн үүрэг /нийц/	(0)	(+1)	(+1)

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Ерөнхий боловсролын сургуулиудад зарцуулах төсвийн хэмжээ нэмэгдэхэд ажилгүйдлийн түвшин буурна (урвуу, хүчтэй хамааралтай), татварын орлогын (орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамж) хэмжээ өснө (шууд, хүчтэй хамааралтай) гэсэн дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Хүчтэй хамаарал нь статистик ач холбогдолтой гарсан байна.

Харин ядуурлын (ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь) үзүүлэлттэй ямар нэгэн хамааралтай гэх үр дүн, дүгнэлт батлагдсангүй.

Эндээс харахад макро үзүүлэлтэд тулгуурласан нийгэм, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарахаас гадна тооцох үзүүлэлтийн хэмжил зүйн асуудлыг сайжруулах хэрэгтэй болох нь харагдаж байгаа юм.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дээр дурьдсан асуудлууд нь ерөнхий боловсролын санхүүжилтийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн үр нөлөөг дээшлүүлэх үндсэн нөхцөл гэдгийг хүлээн авч, бүх шатны удирдлагын түвшинд анхаарч ажиллах орчинг бүрдүүлэх, улмаар ерөнхий боловсролын санхүүжилтийг нэмэгдүүлэх, түүний үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй юм. Үүний тулд судалгааг давтамжтай, дэлгэрүүлэн хийх үзүүлэлтийн хэмжил зүйн асуудлыг сайжруулах, хамаарал, зүй тогтол нь илрэхгүй, оновчтой тайлбарлаж чадахгүй байгаа үзүүлэлтийг боловсролын салбарт удирдлага, мэдээллийн цогц тайлагналтын тогтолцоогоор шийдвэрлэх зэрэг олон асуудлууд байсаар байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн хориод жилийн хугацаанд манай орны бүх шатны боловсролын салбарт өөрчлөлт, шинэчлэлт эрчимтэй явагдаж байна. Төрөөс ихээхэн анхаарал хандуулан боловсролын тогтолцоог дэлхийн нийтлэг системд ойртуулахад чиглэсэн үндэс суурийг тавьж, хөгжүүлэх талаар тодорхой ажлууд хийгдэж байна. Мөн түүнчлэн боловсролын салбарын дотоод, гадаад тодорхой хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлснээр сургалтын орчин, техник

хэрэгслийн хангамжийг сайжруулж ирсэн байна. Боловсролын салбарт шийдэх асуудал байгаагийн амин сүнс нь санхүүжилт, төсвийн удирдлага, нөөцтэй холбоотой байдаг учир судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсын боловсролын санхүүжилтийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар төдийгүй хөгжлийн цогц, уялдаатай бодлого, хөтөлбөрийг боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх механизм, хариуцсан институцийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, цаашдын шийдэгдэх шаардлагатай алхамуудыг гаргаж ирэх хэрэгцээ байна.

Хоёр. Боловсролын статистик үзүүлэлтийн хэмжил зүй болон мэдээллийг хэрэглэгч, үйлдвэрлэгч /мэдээлэгч/ нарын хамтын ажиллагааг дээшлүүлэх, бэхжүүлэх шаардлага байна.

Гурав. Аж үйлдвэрийн IV хувьсгал, ногоон хөгжил, цахим сургалтын орчинг хөгжүүлэх зэрэг шаардлагын үүднээс суралцагч болон багшийн хөгжилд чиглэсэн зардал, санхүүжилт шинээр төлөвлөгдөж байна. Үүнээс гадна сургалтын таатай орчинг бүрдүүлэхийн тулд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, ногоон байгууламжийг бий болгох, усан сан (бассейн), хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, номын сан, лаборатори бүхий иж бүрэн, цогцолборыг бий болгоход чиглэсэн санхүү, хөгжлийн төсвийг бий болгож удирдах (ялангуяа тэдгээрийн үр ашиг, үр нөлөөг тооцох) шаардлагатай гэж үзэж байна.

Дөрөв. Тогтвортой, урт хугацааны санхүүгийн бодлогыг улс болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхүйц боловсролын салбарт мэргэшсэн санхүүгийн удирдлага, хүний нөөц (төрийн санхүүч, эдийн засагч, судлаач) –ийг бэлтгэх, орон нутгийн боловсролын байгууллагуудыг мэргэшсэн хүний нөөцөөр хангах асуудлыг төр бодлогоор дэмжих хэрэгцээ, шаардлага байна.

НОМ ЗҮЙ

- Berne, R., Stiefel, L. (1994). *Measuring equity at the school level: The Finance perspective. Educational Evaluation and Policy Analysis*, 16-4, 405-421.
- Blank, R. (2002). Evaluating Welfare Reform in the United State. *Journal of Economic Literature, American Economic Association* 40, p.1105-1166.
- Doltan, P., Levacic, R., Vignoles, A. (2004). *The economic impact of schooling resources, . Human capital over the life cycle*, p.36-52.
- Guthrie, J. (2006). *Modern education finance*. American Education Finance Association.
- Hanushek, Rivkin, Taylor . (1996). *Aggregation and the estimated effects of school resources*. Review of Economics and Statistics, 78/4/11, p.611-627.
- Odden, A. (2000). The new school finance: Providing adequacy and improving equity. *Journal of Education Finance*, 25/4, p.467-487.
- OECD. (1998). *Human Capital Investment: An International Comparison*. Paris: OECD.
- OECD. (2015). *Compendium of Productivity Indicators*
- Preston, J and Green, A. (2003). *The Macro-Social Benefits of Education, Training and Skills in Comparative Perspective*. Centre for Reseach on the Wider Benefits of Learning. №9.
- Scheerens, J. (2004). *Review of school and instructional effectiveness research*. Paris: UNESCO.
- UNESCO . (2019). *Global Education Monitoring Report 2019: Migration, displacement and education: BUILDING BRIDGES, NOT WALLS*. Paris: UNESCO.
- UNESCO. (2009). *CONFITEA-VI: Belem Framework for Action*. Belem, Brazil: UNESCO.
- UNESCO. (2009). *Education Indicators Technical guidelines*. UNESCO Institute for Statistics.
- UNESCO. (2015). *Rethinking Education. Towards a global common goods*. UNESCO.
- UNESCO. (2018). *Quick Guide to Education Indicators for SDG 4*. UNESCO, Institute for Statistics.

UNICEF. (2016). "Child-focused Public Expenditure Measurement: A Compendium of Country Initiatives"

UNICEF. (2017). "UNICEF's Engagements in Influencing Domestic Public Finance for Children (PF4C) A Global Programme Framework"

Woodhall, M. (2004). *Cost-benefit analysis in education planning*. Spain: UNESCO.

АХБ. (2019). *Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтын тайлан*.

Бандий, Р. (1995). "Боловсролын эдийн засаг" Боловсролын удирдлага онолын асуудал УБ 1995. тал 35-43

Бандий, Р. (2002) "Боловсрол тэргүүлэх салбар болох ерөнхий шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь" Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллийн түүвэр - ХХ зуун. тал 77-83

Бандий, Р. (2001). "Боловсролын зах зээлийн онцлог, түүний маркетингийг хөгжүүлэх асуудал" ХХ зууны Монголын Боловсрол судлал тал 124-134

Батболд, Т. (2014). "Монгол Улс дахь боловсролын хөрөнгө оруулалтын өгөөжийн шинжилгээ" диссертаци

Батцэцэг, С. (2022). "Ерөнхий боловсролын санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх зарим асуудал" диссертаци

Бэгз, Н. (2011). "Глобальчлалын үеийн Монгол улсын боловсролын хөгжлийн онол, арга зүйн үндэс асуудлууд" диссертаци

Бэгз, Н., Санжаабадам, С., нар. (2018). *Хүүхэд залуучуудын хөгжлийн онол, аргазүй*.

ДБ. (2009). "Төсвийн зардал, санхүүгийн удирдлагын тойм судалгаа"

ДБ. (2014). "Монгол улсын боловсролын салбарт үзүүлж буй гадаадын зээл, тусламжийн чиглэл, үр дүн нөлөөллийн судалгаа"

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд мэдээллийн хязгаарлагдмал байдал болон арга зүйн шийдлийн хувьд тусалж дэмжсэн профессор Р.Бандий багшдаа болон БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ҮСХ-ны хамт олонд талархал илэрхийлж байна.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс: С.Б., О.И; Арга зүй: С.Б., О.И; Мэдээлэл цуглуулалт: С.Б., О.И; Бичилт (эхний хувилбар): С.Б., О.И; Бичилт (хянах, засварлах): С.Б., О.И., Т.Г;